



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 88

Мандалговь

Хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дах заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 6 дугаар зүйлийн 6.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Дундговь аймаг дахь Цагдаагийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2017 оны 13-07-016/02 дугаар дүгнэлтээр цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон 98,537,949 /ерэн найман сая таван зуун гучин долоон мянга есөн зуун дөчин ес/ төгрөгийн балансын үнэтэй, 92,379,327 /ерэн хоёр сая гурван зуун далан есөн мянга гурван зуун хорин долоо/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Замын цагдаа, Мөрдөн байцаах тасгийн барилгыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Дундговь аймаг дахь Цагдаагийн газрын дарга (Г.Наранбаатар)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг акталж, данснаас хасах, акталснаас гарах материалыг эргэлтийн хөрөнгөд бүртгэж авах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ӨД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 05 дугаар сарын
20-ны өдрийн 28... тогтоолын хавсралт

Актлах хөрөнгийн мэдээлэл

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалт ад орсон огноо	хэмж их нэгж	Тоо хэмжэ э	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагд сан элэгдэл	Үлдэгдэл өргөг	Данснаас хасах болсон шалтгаан	Актлах төрөл /1. Устгах 2. Худалдах 3. Сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах 4. бусад/
1	ЗЦАлба МБТасгийн конгор	1985.01.01	ш	1	98,537,948.67	98,537,948.67	6,158,621.70	92,379,326.97	Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2017.01.09 13-07-016/02 дүгнэлт	3